



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТАНИЛЦУУЛГА

2024 оны 07 сарын 18 өдөр

Дугаар СХМ - 2024/03

Сүхбаатар сум

「 Алтанбулаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн
хурлын Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт
шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 01 дугаартай “Санхүүгийн хяналтын ажлын удирдамж”-аар Алтанбулаг сум дахь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2 Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Ахлах дотоод аудитор Т.Мөнхзул, Дотоод аудитор Г.Дорждэрэм нарын бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 07 дүгээр сарын 08-ны өдрөөс ажлын 7 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтад Алтанбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал (цаашид ИТХ гэх)-ын 2024 оны эхний хагас жилийн санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4 Алтанбулаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь улсын бүртгэлийн 3753875 дугаар регистртэй, 1370002071 дугаарт бүртгэлтэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100130154001 данстай.

Санхүү, татварын баримтад 1-р гарын үсгийг ИТХ-ын нарийн бичгийн дарга Т.Уянга, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Б.Болорцэцэг нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, мэдээ тайланг гаргаж ирсэн байна.

1.5 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 41 дүгээр хуралдаанаар сумын ИТХ-ын ажлын албаны бүтэц орон тоог баталсан байна.

Сумын ИТХ нь 21 төлөөлөгчтэй, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хороо, Төсөв санхүү хөрөнгө оруулалт эдийн засгийн бодлогын хороо, Нийгмийн бодлогын хороо, Өргөдөл гомдол

хууль хяналтын бодлогын хороо зэрэг хурлын хороо байгуулан ажиллуулж, хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

1.6 Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хуралдуулдаг. Тайлант хугацаанд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан 3 удаа, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл 6 удаа, багийн иргэдийн Нийтийн Хурал тус бүр 1 удаа хуралдуулсан. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаан, багийн иргэдийн Нийтийн Хуралдаан, сургалт, бодлогын хороодын хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэгт ажлын албаны зүгээс голлон анхаарч ажилласан байна.

1.7 2024 оны эхний хагас жилийн байдлаар ИТХ нь 3 удаа хуралдаж газар зохион байгуулалтын 2023 оны гэрээг дүгнэх 2024 оны төлөвлөгөө хэрэгжилтийн талаар 1, мод бэлтгэлийн ажлаар 1, хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн 1, 2024 оны төсөл сонгон шалгаруулах ажлын талаар 1, малын тоо толгойн албан татвар болон мал амьтны шимэгчтгэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлаар 2, бусад чиглэлээр 13, нийт 20 асуудлыг шийдвэрлэж ИТХ-ын тогтоолоор баталгаажуулсан байна.

Үүнд:

№	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуралдсан огноо	хурлаар		Ирц /Хувь/
		Хэлэлцсэн асуудал	Шийдвэрлэлт (тогтоолын дугаар)	
1	2024.01.30.	Түлээний модны хуваарь батлах тухай	126	85.7%
2		Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөний биелэлт, 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай	127	
4		Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөлд зээл олгох тухай салбар чиглэл батлах тухай	128	
5		Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах тов тогтоох тухай	129	
6		Мал амьтны шимэгчтгэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөө батлах	130	
7		Малын тоо толгойн албан татварт өөрчлөлт оруулах тухай	131	
8		Бодлогын хороодын төлөвлөгөө батлах тухай	132	
9		Журам батлах тухай	133	
10		Сонгуулийн хэсэг байгуулах тухай	134	
1		2024.04.09	МУИХ-ын сонгуулийн зурагт самбарыг байршуулах байршил тогтоох тухай	
2	Сумын ИТХ-ын сонгуулийн Төлөөлөгчдийн мандатын тоо батлах тухай		136	
3	Сэлэнгэ аймгийн Прокурорын тогтоолын тухай		Тогтоол гараагүй	
4	Алтанбулаг суманд газар эзэмших ашиглах гэрээ дүгнэх ажлын хэрэгжилтийн талаар		137	
5	2024 оны Улс, аймаг, сумын төсөв ОНХС-аар хийгдэх хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил арга хэмжээний явцын талаар		Тогтоол гараагүй	

6		2023 онд унасан мод бэлтгэлийн ажлын талаар	Тогтоол гараагүй	
7		Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн захирамжийн талаар	Тогтоол гараагүй	
8		Халаалтын төвийн тухай	138	
1	2024.05.20	Сумын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай	139	61,9%
2		Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай	140	
3		Хөрөнгө актлах тухай	141	
4		Өмч ашиглуулах тухай	142	
5		Хүлэмж, парк, усалгааны тоног төхөөрөмж		
6		Хогны автомашин ашиглуулах Шахмал түлшний цехийн тоног төхөөрөмж	143	
7		Сонгуулийн хэсэг байгуулах тухай		
8		Ээлжийн амралт олгох тухай	144	

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

Тус сумын ИТХ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим системд нийт 82 мэдээлэл байршуулахаас 2024 онд бүх мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээллэж хуулийн хэрэгжилтийг 100% хангасан байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

Сумын ИТХ-ын төсөв нь үйл ажиллагааны болон ажлын албаны төсвөөс бүрддэг бөгөөд 2024 оны эхний хагас жилийн байдлаар 5 арга арга хэмжээг санхүүжүүлэхээр 92,819.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж 84,566.2 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 83,016.7 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 91% хувь байна.

№	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт /-/
1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	76,462.6	70,967.3	5,495.3
2	80205- Мэдээлэл, сурталчилгааны зардал	294.0	-	-
3	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж	9,582.0	9,110.7	471.4

4	80825- БИНХ-ын даргын урамшуулал	4,275.0	4,161.3	113.7
5	82201-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал	2,500.2	327.0	2,173.2
Нийт		93,113.8	84,566.2	8,253.6

2.2.2. 2024 оны үйл ажиллагааны батлагдсан төсөв, гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав:

Хүснэгт 1.

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024 оны эхний хагас жил		хэмнэлт/+/ хэтрэлт /-/
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Үндсэн цалин	47,322.90	31,711.70	15,611.20
2	Нэмэгдэл	8,500.70	23,092.00	-14,591.30
4	Урамшуулал	6,366.20	5,471.10	895.1
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын дүн	62,189.80	60,274.70	1,915.10
6	Ажил олгогчоос төлөх НД-ын шимтгэл	8,036.10	7,229.80	806.3
7	Бичиг хэрэг	544.8	394.4	150.4
8	Тээвэр, шатахуун	1,587.00	1,483.40	103.6
9	Шуудан, холбоо, интернэт	439.8	320.8	119
10	Бага үнэтэй түргэн элэгдэх	288.6	232.8	55.8
11	Хангамж бараа материалын зардлын дүн	2,860.20	2,431.40	428.8
12	Нормын хувцас, зөөлөн эдлэл	86.4		
13	Нормативт зардал	86.4		
14	Багаж, техник, хэрэгсэл	865.8		865.8
16	Эд хогшилын зардлын дүн	865.8		865.8
17	Дотоод албан томилолт	817.8	236	581.8
18	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,750.00	1,497.80	2,252.20
19	Аудит, баталгаажуулалт	184.7		
20	Тээврийн хэрэгслийн даатгал татвар оношлогоо	215.8		
23	БГАУ, бараа үйлчилгээний бусад зардлын дүн	4,150.50	1,128.20	3,022.30
24	Бараа үйлчилгээний бусад зардал	3,365.40	3,235.80	129.6
25	Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал	865.8	550	315.8
26	Бараа үйлчилгээний бусад зардал	4,231.20	3,785.80	445.40
27	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	9,582.00	9,110.70	471.3
28	Урсгал шилжүүлэгийн дүн	9,582.00	9,110.70	471.3
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		92,819.80	84,196.60	8,536.80

№	Үзүүлэлт	2024 оны эхний хагас жил		хэмнэлт/+/ хэтрэлт /-/
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Үндсэн цалин	47,322.90	31,711.7	15,611.20
2	Нэмэгдэл	8,500.70	23,092.0	-14,591.30
4	Урамшуулал	6,366.20	5,471.1	895.10
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын дүн	62,189.80	60,274.7	1,915.10
6	Ажил олгогчоос төлөх НД-ын шимтгэл	8,036.10	7,229.8	806.30
7	Бичиг хэрэг	544.8	394.4	150.40
8	Тээвэр, шатахуун	1,587.00	1,483.4	103.60
9	Шуудан, холбоо, интернэт	439.8	320.8	119.00
10	Бага үнэтэй түргэн элэгдэх	288.6	232.8	55.80
11	Хангамж бараа материалын зардлын дүн	2,860.20	2,431.4	428.80
12	Нормын хувцас, зөөлөн эдлэл	86.4		
13	Нормативт зардал	86.4		
14	Багаж, техник, хэрэгсэл	865.8		865.80
16	Эд хогшилын зардлын дүн	865.8		865.80
17	Дотоод албан томилолт	817.8	236.0	581.80
18	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,750.00	1,497.8	2,252.20
19	Аудит, баталгаажуулалт	184.7		
20	Тээврийн хэрэгслийн даатгал татвар оношлогоо	215.8		
23	БГАУ, бараа үйлчилгээний бусад зардлын дүн	4,150.50	1,128.2	3,022.30
24	Бараа үйлчилгээний бусад зардал	3,365.40	3,235.8	129.60
25	Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал	865.8	550.0	315.80
26	Бараа үйлчилгээний бусад зардал	4,231.20	2,605.9	1,625.30
27	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	9,582.00	9,110.7	471.30
28	Урсгал шилжүүлэгийн дүн	9,582.00	9,110.7	471.30
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		92,819.80	83,016.70	9,716.70

- 1. Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:** Үйл ажиллагааны урсгал зардлыг 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт төсвийг 96.9%-аар тус хэмнэн ажилласан боловч цалингийн нэмэгдэлд 8,500.7 мянган төгрөг батлагдаж, 23,092.0 мянган төгрөгийг зарцуулж, нэмэгдлийг 14,591.30 төгрөгөөр хэтрүүлж үндсэн цалингаас олгосон байна.
- 2. ЭМНДШ-ийн зардал:** Ажил олгогчоос 10%-12.5%-аар тооцон ажилтны төлсөн шимтгэлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад шилжүүлж, сар бүр НД 8 маягтаар тайлагнасан байна. НДШ-ийн авлага 168.9 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгасан

3. **Хангамж бараа материалын зардал:** 2024 онд бараа материалын зардалд 2.860.2 мянган төгрөг батлагдаж 2,431.4 мянган төгрөгийг зарцуулжээ. Бараа материалыг бүртгэлд тусгахдаа худалдаж авсан тухай бүр орлого авдаггүй улирал тутамд бөөн дүнгээр орлогод бүртгэсэн байна. Шатахууны зарцуулалтыг шаардах хуудас, маршрутыг үндэслэн зарлагдаж бүртгэсэн байна.
4. **Томилолтын зардал:** 2024 онд 817.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас эхний хагас жилийн байдлаар 236.0 мянган төгрөгийн зарцуулж тайлагнасан байна.
5. **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж:** 2024 онд 4,150.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас эхний хагас жилийн байдлаар 1,128.2 мянган төгрөг зарцуулсан.
6. **Бусад зардалд:** 2024 онд 4,231.2 мянган төгрөг батлагдсанаас эхний хагас жилийн байдлаар бараа үйлчилгээний бусад зардалд 3,235.8 мянган төгрөгийг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 550.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Үүнээс Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 327.0 мянган төгрөг зарцуулсан баримттай байна.
7. **Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал:** 2024 онд сумдад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдад таван жил ажилласны мөнгөн урамшуулал олгох 9.582.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 9,110.7 мянган төгрөг зарцуулсан.

Нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардал хүрэлцэхгүйн улмаас ажлын албаны эрүүл мэндийн үзлэгийн төлбөр 518.4 мянган төгрөгийг цалингийн урамшууллын зардлаас, ахмад настны сар шинийн хүндэтгэлийн арга хэмжээний 1,220.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас, нийт 1,738.4 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал буруу зарцуулсан байна.

2.3. Санхүүгийн үйл ажиллагааны явц, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Үндсэн хөрөнгө: ИТХ нь 2024 оны эхэнд авто тээврийн хэрэгсэл 14850.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 11428.7 мянган төгрөг, тавилга эд хогшил 3,881.0 мянган төгрөгийн нийт 30,159.7 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй, тайлант онд 360.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг төсвийн хөрөнгөөр бий болгож 30,519.7 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Дээрх хөрөнгийг санхүүгийн тайлан бүртгэлд тусгасан байна.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 5.4-т заасан "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа"-тай тулган баталгаажуулахыг зөвлөв.

Бараа материал: 2024 онд бараа материалын эхний үлдэгдэл 3,602.1 мянган төгрөг, орлого 5,262.7 мянган төгрөг, зарцуулалт нь 4,700.7 мянган төгрөг, эхний хагас жилийн байдлаар 4,164.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд ГХУСС зөвлөлийн зардалд 252.0 мянган төгрөг, шатахууны зардалд 1,483.4 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1,080.1 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 261.0 мянган төгрөг бусад бараа материалын зардалд 2,624.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан баримттай.

Өмч хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2.

(мянган төгрөгөөр)

№	Хөрөнгийн хөдлөлийн утга	Орлого зарлагын гүйлгээний утга	Өмч хөрөнгө:	
			Үндсэн хөрөнгө	Бараа материал
1	Оны эхний үлдэгдэл		30,159.7	3,602.1
2	Төсвийн эх үүсвэрээр	худалдан авсан	360.0	5,262.7
3	Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс	шилжүүлэн авсан	-	-
4	Бусад /дахин үнэлсэн/	шилжүүлэн авсан	-	-
5	Бусад			
6	Орлогын дүн		360.0	5,262.7
7	Үйл ажиллагаанд зарцуулсан	анхан шатны баримт	-	4,700.7
8	Байгууллагуудад шилжүүлсэн	шилжүүлсэн	-	-
9	Акталж данснаас хассан	тушаалаар		
10	Зарлагын гүйлгээний дүн			4,700.7
11	Оны эцсийн үлдэгдэл		30,519.7	4,164.1

Бараа материалын орлого болон зарлагыг тухай бүр хүлээн зөвшөөрч, тайлан бүртгэлд тусгаагүй улирлаар бөөн дүнгээр бүртгэсэн байсныг хяналт шалгалтын явцад залруулсан.

2.4 Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

2024 оны эхний хагас жилийн байдлаар сумын ИТХ-ын ажлын албаны цалинг 2 удаа шинэчлэн баталсан байна.

2024 онд сумын ИТХ-ын ажлын албанд ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэл хийсэн дүн шинжилгээ хийлээ:

Хүснэгт 3.

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	ИТХ		БИНХ	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	Үндсэн цалин	47,322.9	31,711.7		

2	Нэмэгдэл цалин	8,500.7	23,092.0		
3	Урамшуулал	6,366.2	1,705.2	3,766.2	3,765.9
5	Цалин хөлс нэмэгдэл дүн	62,189.8	56,508.9	3,766.2	3,765.9
5	Ажил олгогчоос төлөх НДШ	8,036.1	6,840.7	508.8	389.1
Цалин хөлс НДШ-тэй холбоотой нийт зардлын дүн		70,225.9	63,349.6	4,275.0	4,155.0
Орон тооны мэдээлэл		3	3	3	3

Сумын ИТХ нь 3, багийн иргэдийн нийтийн хурал 3, нийт 6 орон тоотойгоор үйл ажиллагааг явуулж цалин хөлс, нэмэгдэлд, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 74,500.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 67,504.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. Нэмэгдэл цалинг 14,591.3 мянган төгрөгөөр үндсэн цалингийн зардлаас шилжүүлэн олгосон байна.

Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажуулахын зэрэгцээ НДШ-ийн дэлгэрэнгүй НД8 тайлантай нэг бүрчлэн тулган шалгахад: багийн ИНХ-ын НДШ-ийг 113.4 мянган төгрөг, сумын ИТХ-ын ажлын албаны НДШ-ийг 55.5 мянган төгрөг, нийт 168.9 мянган төгрөгөөр илүү шилжүүлж, НДШ-ийн авлага үүсгэсэн байна.

2.5 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Тус сумын ИТХ нь 2024 онд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх томоохон худалдан авалт байхгүй байна. Үүнд:

Хүснэгт 4.

(мянган төгрөгөөр)

Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл,	Төрөл (бараа, ажил, үйлчилгээ)	Төсөвт өртөг (мян.төг)	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, арга	Тайлбар, тодруулга
Нормын хувцас, зөөлөн эдлэл	Бараа	172.3	ШГБ	ТБОНӨХБАҮХАТ хуулийн босго онооноос доогуур
Хангамж бараа материал	Бараа	2,431.4	ШГБ	
Багаж, техник, хэрэгсэл	Бараа	1,731.2	ШГБ	
Бараа үйлчилгээний бусад зардал	Үйлчилгээ	6,731.2	ШГБ	
Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал	Үйлчилгээ	1,731.2	ШГБ	

Сумын ИТХ нь 2024 онд төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний 12,797.3 мянган төгрөгийн гэрээг нийт 3 иргэн, аж ахуй нэгж байгууллагатай гэрээг байгуулсан, төлбөр тооцооны үлдэгдлийг тооцооны үлдэгдлийн баталгааны маягаар баталгаажуулаагүй, гэрээний хэрэгжилтийн үр дүнг тооцоогүй байна.

2.6. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайланд хяналт тавих

1. Анхан шатны баримтын бүрдэл

- Үндсэн хөрөнгө, бараа материал худалдан авалт, анхан шатны баримтын иж бүрдлийг тулган шалгахад тайлант хугацаанд Төнөр инк сервис ХХК-аас 99.0 мянган төгрөгийн, Монголын улаан загалмайн нийгэмлэг ҮХБ-аас 369.0 мянган төгрөгийн нийт 468.0 мянган төгрөгийн худалдан авсан бараа, ажил гүйлгээний нэхэмжлэх, и-баримт нь бөөн дүнгээр бүртгэгдсэн байна.
- Үндсэн хөрөнгийн тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 14,850.0 мянган төгрөгийн өртөгтэй автомашины ашиглалтын хугацааг буруу бүртгэснээс элэгдлийн зардлыг 3,960.0 мянган төгрөгөөр илүү байгуулж, тайлагнасан байна.
- “Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх” тухай ИТХ-ын нарийн бичгийн даргын 2024 оны 02 сарын 07-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар 20 ахмад настанд сар шинийн хүндэтгэл үзүүлж 1,220.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажлын гүйцэтгэл тайлан хэт товч, тодорхой бус тул тайланг дэлгэрэнгүй бичүүлж, ИТХ-ын нарийн бичгийн даргаар баталгаажуулсан .

2. Шатахуун зарцуулалт

НИК ХХК-тай гэрээ байгуулж, шатахууны дараа төлбөрт кредит карт ашиглан эхний хагас жилийн байдлаар 1,735.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. Анхан шатны баримтын бүрдлийг тулган шалгахад:

- жолоочийн тооцооны хуудас бүрэн хөтлөөгүй (ирсэн, явсан цаг, спидотерийн заалт, шатахуун зарцуулалтын норм, гарын үсэг дутуу гэх мэт)
- Сэлэнгэ аймгийн сум хоорондын батлагдсан зай, хэмжээг баримталж ажилладаггүй байна.

Шатахууны дараа төлбөрт кредит карт ашиглах нь төсвийн байгууллагад тохиромжгүй анхан шатны баримтыг шатахуун ашигласан тухай бүр бүрдүүлж, хянах боломж багатай, тухайн сарын төсөв хэтрүүлж зарцуулах боломжтой тул цаашид шатахууны гэрээг шинэчлэн байгуулж, шатахууны талон ашиглаж байх нь тохиромжтой

3. ИТХ хуралдааны зардал

Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн хуралдааны хоолны зардалд 4 аж ахуйн нэгж байгууллагад 1,464.7 мянган төгрөг шилжүүлсэн байна.

ИТХ-ын хуралдааны зардлыг төсөвт багтаан зарцуулсан бөгөөд анхан шатны баримт (төсөв, ирцийн бүртгэл, хурлын тэмдэглэл гэх мэт)-д он, сар, гарын үсэг дутуу байсныг шалгалтын явцад залруулсан.

2.7 Өмнөх шалгалтын талаар

Хүснэгт 6.

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн шийдвэрлэлт	2023 он	
	Үзүүлэлт	Биелэлт

	Тоо	Дүн	Тоо	Дүн	хувь
Төлбөрийн акт	1	668.1			0
Нийт дүн	1	668.1			0

Төрийн аудитын байгууллагаас хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтаар 2023 онд ИТХ-ын төлөөлөгчдийн хуралдааны үеийн хоолны зардлыг бодит ирцээр бус төлөөлөгчдийн тоогоор тооцож илүү зарцуулсан 668.1 төгрөгийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор төлбөрийг барагдуулахаар ажиллаж байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Алтанбулаг сумын ИТХ-ын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар журнал хөтлөлт, шилэн дансны цахим хуудасны хөтлөлтөөр хангалттай сайн, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан зэрэг ололт бүхий нөхцөл байдал тогтоогдсон бол хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн бүртгэл хөтлөлтийн анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй дараах зөрчил, дутагдал илэрсэн. Үүнд:

Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудалтай холбоотой зөрчил дутагдал:

Илрүүлэлт 1. Ажлын албаны албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгийн төлбөр 518.4 мянган төгрөгийг цалингийн урамшууллын зардлаас гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын 210901, гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Илрүүлэлт 2. Шатахууныг Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан нормын дагуу тооцоогүйгээс 671.9 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3.3, 3.6, 6.4 дахь заалтуудыг, Зам тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" нэгдүгээр хавсралттай нийцэхгүй байна.

Илрүүлэлт 3. Ахмад настны хүндэтгэлийн арга хэмжээний 1,220.0 мянган төгрөг, ИТХ-ын хуралдааны зардал 107.0 мянган төгрөг бүгд 1,327.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас, ИТХ-ын хуралдааны зардал 232.8 мянган төгрөгийг бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийн ангиллаас нийт 1,559.8 мянган төгрөгийг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

Илрүүлэлт 4. Автомашины ашиглалтын жилийг үндэслэлгүй тогтоосноос элэгдлийн зардлыг 3,960.0 мянган төгрөгөөр илүү байгуулж тайлагнасан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 5.4-т заасан "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа"-тай нийцэхгүй байна

Илрүүлэлт 5. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил гүйлгээний цахим төлбөрийн баримтыг бөөн дүнгээр бүртгэсэн 468.0 мянган төгрөгийн худалдан авалт байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм..." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Алтанбулаг сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан 2024 оны эхний хагас жилийн санхүү, төсөв, бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Дунд" эрсдэлтэйд тооцож, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, сумын ИТХ-ын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааны горимыг баримталж ажилласан байна гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Алтанбулаг сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 7,178.1 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн хугацаатай 1,190.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 5,519.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэх, төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил гүйлгээний цахим төлбөрийн баримтыг бөөн дүнгээр бүртгэсэн худалдан авалт хийхгүй байх 1 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Хяналт шалгалтын явцад залруулах боломжтой анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлттэй холбоотой 12,456.5 мянган төгрөгийн зөрчил дутагдлыг залруулсан.

Тав.Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулж 1,190.3 мянган төгрөгийн төлбөрийн актыг төсвийн дансанд төвлөрүүлэх, 5,519.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн болно.

Шалгалтын тэмдэглэлд тусгагдсан үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах, зөрчлийг арилгасан тухайгаа 2024 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр мэдэгдэхийг тус сумын ИТХ-ын дарга, нягтлан бодогч нарт хариуцуулав.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД
АУДИТОР *Б.Дорждэрэм* ДОРЖДЭРЭМ

